

IV. ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

ИХ ХҮРЭЭНИЙ ХАМБА НОМУН ХАН АГВААНХАЙДАВЫН НАМТАРТ ХОЛБОГДОХ МАНЖ БИЧГИЙН ХОЁР БАРИМТ

Э.Жигмэддорж. ШУА-ийн Түүхийн хүрээлэн.
e_jigmed@yahoo.com

Товч утга: Монгол Улсын Үндэсний Төв Архивт буй цорж Агваанхайдавын намтарт холбогдох манж бичгийн хоёр баримтыг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж, тэрбээр Их Хүрээний анхны дэд хамба болсон тухай товч өгүүлжээ.

Түлхүүр үг: Үндэсний Төв Архив, манж бичгийн данс, дэд хамба, Агваанхайдав

Оршил

Монголын буддын гүн ухааны томоохон төлөөлөгч Агваанхайдав 1779 онд Халхын Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошууны нутагт төржээ*¹. Тэрбээр бага наснаас номын мөр хөөн, Их хүрээ, Гомон хийдэд шавилан сууж, цорж, дэд хамба, хамба номун хан зэрэг шашны өндөр тушаал, мяндаг хүртжээ.

Агваанхайдав Хүрээний хутагт хувилгаан, лам нарын дотроос анх удаа “дэд хамба”-ын тушаалд суусан гэдэг. Харин зарим бүтээлд Хамба номун хан Лувсанпэринлэйдандар (1764-1822) анх удаа дэд хамбын тушаал хүлээсэн хэмээн бичжээ².

Эндээс Их Хүрээний дэд хамбын албан тушаалд анх хэн гэдэг хүн, хэдийд суусан бэ? гэсэн асуулт гарч байна.

Бид Монгол Улсын Үндэсний Төв Архивын “Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яам”³ (ҮТА. ФМ-1.)-ны фондод Агваанхайдавын намтарт холбогдох манж хэлээрх хоёр сонирхолтой бичиг буйг олж үзэв. Үүнд,

1. Хүрээний сайдын газраас цорж Агваанхайдавыг дэд хамбын тушаалд томилуулахаар Манжийн хаанд өргөсөн айлтгал
2. Төр гэрэлт хаанаас Эринчинжавыг Хүрээний хамба номун хан, цорж Агваанхайдавыг дэд хамбын тушаалд тавих тухай буулгасан зарлиг болно.

Уг хоёр бичиг “Хүрээн дэх манж сайдын яамнаас Манжийн хаанд айлтгасан хэрэг, Манжийн хаанаас буулгасан зарлигуудын хуулга данс” (ҮТА. ФМ-1, Т-1, ХН-812.)-д тэмдэглэгдэн үлдсэн ба өмнө нь судалгааны эргэлтэнд төдий л ороогүй бололтой.

Энэхүү илтгэлд эдгээр бичгийг манж хэлнээс хөрвүүлэн танилцуулахын хамт цорж Агваанхайдав Хүрээний дэд хамба болсон тухай товч өгүүлэхийг хичээв.

1.1. Хүрээний сайдын яамны тухай товчхон:

Манж Чин улсаас Ар Монголд байгуулсан засаг захиргааны нэг томоохон нэгж бол одоогийн Улаанбаатар хотод байсан Хүрээ сайдын яам юм. Хүрээнд 1758 онд монгол,

*¹ Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошуу - - Одоогийн Төв аймгийн Баяндэлгэр, Эрдэнэ, Баян, Сэргэлэн, Мөнгөнморьт, Баянзүрх, Ар хуст, Алтанбулаг, Багануур, Найлайх, Улаанбаатар хотын хавь газар, Баянцагаан, Баянжаргалан, Аргалант, Өнжүүлийн зарим нутаг болно. - Ц.Сономдагва. Монгол Улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэл (1691-1997). Нэмж засварласан Ч.Банзрагч, О.Батсайхан. УБ., 1998. т.22

² Ө.Сэрээтэр. Монголын Их хүрээ, гандан хийдийн түүхэн бүтэцийн товч. 1651-1938. УБ., 1999. т.103

*³ Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яам - Манж Чин улсаас Ар Монголд байгуулсан төр захиргааны нэг томоохон газар бол одоогийн Улаанбаатар хотод сууж байсан “Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яам” болой.

1761 онд манж сайд тус тус томилогдон сууснаар энэ сайдын газар байгуулагджээ. Манжийн хааны зарлигаар олгосон энэ сайдын уг нэр нь “Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд”^{*4} хэмээнэ.

Хүрээ сайдын газар Жибзундамба хутагтын шавь, Түшээт хан, Сэцэн хан хоёр аймаг, Хүрээ ба Хиагтын заргачийн газар, Хиагтын зүүн талын гэр харуул, Хүрээнээс Хиагт хүртлэх хойт замын суурь өртөө, мөн Хүрээнээс Сайр ус хүртлэх өмнөт замын 14 буухиа өртөөг харьяалан захирч байв.

Хүрээ сайд нь өөрийн захирсан аймаг, шавь, өртөө, харуулын зэрэг газруудаас ирсэн бичиг сэлтийг хүлээн авч өөрөө шийдвэрлэх буюу Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яам болон Манжийн хаанд уламжилан мэдүүлэх, дээрээс ирсэн захиа зарлигыг хэрэгжүүлэх үүрэг хүлээж байжээ.

Монгол Улсын Үндэсний Төв Архивын “Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яам”(ҮТА.ФМ-1.)-ны фонд нь агуулга, хамрах хүрээ, он цагийн хувьд XVIII-XIX зууны үеийн Монголын түүхэнд холбогдох үлэмж хэмжээний бичиг баримт агуулж буй сан хөмрөг юм^{*5}.

Энэхүү хөмрөгт Монголын хутагт хувилгаад, Хүрээний хамба номун хан, дэд хамба, да лам, цорж нарын намтар, үйл ажиллагаанд хамаарах олон арван данс хараа агуулагдаж байна.

1.2. *Судалгааны бүтээлүүдэд Агваанхайдав Хүрээний дэд хамба болсон тухай өгүүлсэн нь:*

Монгол Улсын судлаачдын бүтээлд Агваанхайдав Хүрээний дэд хамбын тушаалд суусан тухай хэрхэн дурьдсаныг товч авч үзье.

Ч.Алтангэрэл “Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл”-дээ “Төр гэрэлт хаанаас дэд хамба нарын эрхэн Да Хамба Номон хааны цол яамба олгожээ”^{*6}

Ө.Сэрээтэр “Хүрээ сайд Юндэндоржийн хүссэний дагуу Төр гэрэлтийн 2-р онд Манж хаанаас анх удаа дэд хамбын тушаалыг буй болгож Лувсанхайдавыг томилжээ”^{*7}

“Монголын философийн түүх” (XVII-XIX зуун) хамтын бүтээлд “Тэрээр нутагтаа буцаж ирээд Их Хүрээний номын багш цорж, дэд хамба, их хамбын сэнтий юуг дараалуулан эзэлж, дээрхийн зарлигаар хамба номун хан цол ямба хүртжээ”^{*8}

Л.Чулуунбаатар “Төвдөөр гийсэн монгол мэргэд” гэдэг номондоо “Л.Агваанхайдав Монголдоо эргэж ирээд их Хүрээний цорж, дэд хамба, их хамбын өндөр тушаалыг удаа дараа гүйцэтгэж ...”^{*9} хэмээн тус тус бичжээ.

Судалгааны бүтээлүүдэд цорж Агваанхайдав Хүрээний дэд хамбын тушаалд суусан тухай тоймлосон байдлаар тусгасан тул үүнийг архивын баримтад тулгуурлан тодруулах нь зүйтэй байна.

2.1. *Хүрээ сайдын айлтгал:*

Хүрээний сайдын газраас Агваанхайдавыг дэд хамбын тушаалд томилуулахаар Манжийн хаанд өргөсөн айлтгал “Хүрээн дэх манж сайдын яамнаас Манжийн хаанд

^{*4} “Хүрээ сайдын яам”-ны тухай судлаач Ц.Сономдагва. Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт (1691-1911). УБ., 1961. т.33-38-аас үзэж болно.

^{*5} “Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яам”(ҮТА.ФМ-1.)-ны сан хөмрөгийн талаар ҮТА-ын ажилтан Ү.Дэлгэрмаа тойм өгүүлэл бичжээ. - Ү.Дэлгэрмаа “Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд”-ын яамны баримтын тойм. - Монгол улсын архивын албаны түүхэн хөгжил, орчин үе (Архивын алба байгуулагдсаны 73 жилийн ойд зориулсан онол-практикийн бага хурлын материал. 2000 оны 12 дугаар сарын 05). Эрхэлсэн Г.Дашням. УБ., 2001. т.64-85

^{*6} Ч.Алтангэрэл. Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл. I дэвтэр. УБ., 1967. т.72

^{*7} Ө.Сэрээтэр. Монголын Их хүрээ, гандан хийдийн түүхэн бүтэцийн товч. 1651-1938. УБ., 1999. т.105

^{*8} Монголын философийн түүх (XVII-XIX зуун). УБ., 2001. т.268

^{*9} Л.Чулуунбаатар. Төвдөөр гийсэн монгол мэргэд. УБ., 2004. т.44

айлтгасан хэрэг, Манжийн хаанаас буулгасан зарлигуудын хуулга данс” (ҮТА, ФМ-1, Т-1, ХН-812)-д тэмдэглэгджээ.

Уг хуулга дансанд Төр гэрэлтийн 2-р (1822) онд Хүрээ сайдын газраас Манжийн хаанд өргөсөн айлтгал болон хаанаас буулгасан зарлигууд багтжээ.

Энэ данс муутуу цаасан дээр бичсэн нийт 45 нүүр, худам монгол бичгээрх нэг баримтаас бусад нь бүгд манж бичгээр сийрүүлэн бичсэн байна.

Дансны гадна нүүрэн талд “toro eldengge i jai aniyade wesimbuhe, jai wasimbuha hese be sarkiyaha danse” (монголоор “**Төр гэрэлтийн хоёрдугаар онд айлтгасан, жич буулгасан, зарлигыг сийрүүлсэн данс**”) хэмээжээ.

Хүрээний сайдын газраас Манжийн хаанд өргөсөн айлтгал нь дансны 26-28 дугаар нүүрэнд буй. Айлтгал нэг нүүрэнд 11 мөрөөр бичсэн нийт 5 нүүрээс бүрдэнэ.

Айлтгалд бичсэнээр уг бичгийг Төр гэрэлтийн хоёрдугаар оны долоон сарын шинийн долоонд хааны гэгээнээ толилуулахаар өргөжээ. Бичгийг дор сийрүүлбэл, (26 а)

01.nadan biyai ice nadan de /

долоон сарын шинийн долоонд*¹⁰

02. aha yun, guwang gingguleme /

боол уун*¹¹, **guwang***¹² **хичээнгүйлэн**

03. wesimburengge, jebzundamba qutugtu i huren i gere lama bandi sabe kadalara doro /

айлтгасан нь, Жэбзундамба хутагтын Хүрээний олон лам банди нарыг захирах тамга

04.bisire nomon han oro tucifi, fe kooli be dahame nomon han /

барих номун хан ор гараад /нас барсанд/, хуучин хуулийг даган номун хан

05.sindaha babe gingguleme /

тавих хэргийг хичээнгүйлэн

06.hese be baime /

зарлигийг гуйн

07.wesimbure jalin, jaha sunja biyai orin duin de nomon han lubsangperinleidandar /

айлтгах учир, мөнөөхөн таван сарын хорин дөрвөнд¹³ **номун хан**

Лувсанпэринлэйдандар*¹⁴

08. nimegulefi beye wacihabi, baicaci abai wehiyehe i aniyen ci ebsai tosan /

өвчилөөд бие барав, байцааваас Тэнгэрийн тэтгэсний оноос нааш тушаал

09.tosan de gemu /

тушаалд цөм

10.wesimbufi sindembime, saicungga fangsa i orin sunjac i aniyen de nomon /

айлтгаад тавих бөгөөд, Сайшаалт ерөөлтийн хорин тавдугаар онд*¹⁵ **номун**

11.han jancuvdorji beye wacifi nerginde /

*¹⁰ **Долоон сарын шинийн долоон** - Төр гэрэлтийн хоёрдугаар оны долоон сарын шинийн долоон болно. В.В.Цыбульский харьцуулсан календариас үзвэл, энэ нь аргын тооллын 1822 оны 8 сарын 23-ны өдөр ажээ. - В.В.Цыбульский. Лунно-соличный календарь стран Восточной Азии. С переводом на даты Европейского календаря (с 1 п 2019 г.н.э). М., 1987. стр.346

*¹¹ **Уун** - Тухайн цагт Хүрээний хэргийг эрхлэн шийтгэх манж болон монгол сайд сууж байв. Энэхүү айлтгалд өөрийн нэрийг “Yun” хэмээн товчилон бичсэн нь Хүрээний монгол сайд Юндэндорж бололтой. Албан бичигт бичиг айлтгагч өөрийн нэрийг товчилон бичих явдал Манжийн үед нэлээд түгээмэл байжээ.

*¹² **Guwang** – Хүрээнд сууж байсан манжийн найман хошууны харьяат түшмэл бололтой.

*¹³ **таван сарын хорин дөрвөн** - Төр гэрэлтийн хоёрдугаар оны таван сарын хорин дөрвөн болно. Энэ нь аргын тооллын 1822 оны 8 сарын 31-ний өдөр ажээ. - В.В.Цыбульский. Лунно-соличный календарь стран Восточной Азии. С переводом на даты Европейского календаря (с 1 п 2019 г.н.э). М., 1987. стр.346

*¹⁴ **Лувсанпэринлэйдандар** - Эрдэнэ бандид хутагтын IV дүр, 1764 онд Их шавийн нэгэн айлд төрж, Сайшаалт ерөөлтийн 25-р (1820) онд Их хүрээний хамба номун ханы тушаал хүлээж 2 жил болоод жанч халжээ.

*¹⁵ **Сайшаалт ерөөлтийн хорин тавдугаар он** - Нийтийн он тооллын 1820 он болой.

хан Жанчувдорж*¹⁶ бие барсан учир

(26 b)

01.wesimbufi /

айлтгаад

02.hesa hesei corji luvsangperinleidandar be sindaha bihe, ere nomon han hoifa /

хишиг зарлигаар цорж Лувсангэринлэйдандарыг тавьсан бөлгөө, энэ номун хан бусад

03.hubilgan lamasa de adali aku, cohudoj jebzundamba hutugtu i sirame /

хувилгаан лам нар лугаа адилгүй, тусгайлан Жавзундамба хутагтын дараа

04.hural nomon de dalambime, juwen tumen hamisara lama bandi sabe hadalara /

хурал номод тэргүүлж, хоёр түмэн ... лам банди нарыг захирах

05.niyalma ofi, ahasa i baci, nomon han i doro be taka /

хүн тул, боол нарын газраас, номун ханы тамгыг түр

06.harangga sanjodba gomjobab de tuwasiyame afabufi, je sonkoi lamasa be /

харьяат шанзодба Гомбожав*¹⁷-д сахиулан тушааж, хуучин ёсоор лам нарыг

07.aktulame tolilame buduliyabuki seme afabuha de, gomjobab se geren /

батлан томилж мэдүүлээр ирүүлсүгэй хэмээн тушаасанд, Гомбожав нар олон

08.ambaga lamasa uhei hebsefi, cihangGai hutugtu i harangga hubilgan erincinjab be /

ихээхэн лам нар бүгд зөвдөж, дуртайя хутагтын харьяат хувилгаан Эринчинжав*¹⁸-ийг

09.cohobume, corji lubsanhaidub be adabume budlayiha be ahasa baicame /

цохуулан, цорж Лувсанхайдавыг*¹⁹ зэрэгцүүлэн мэдүүлснийг боолчууд байцааж

10.tuwaci, hubilgan erincinjab husin hamisara se, erei onkolo wargi zan de /

үзээд, хувилгаан Эринчинжав гучин ... нар, үүний урьд баруун Занд

11.jebzundamba hutugtu be tuwasadame yabuha bime, nomo tacihangga honu ombi /

Жавзундамба хутагтыг харалцан явсан бөгөөд, ном сурсан нь харин ч болмуу

(27 a)

01.hacin aku, geli baicaci erincinjab onkolo geli /

зүйл үгүй, бас байцааваас Эринчинжав урьд бас

02.abai genggiyen be harasame henggileme yabuha babe, ahasa bahaci udhai fe /

тэнгэрийн гэгээн*²⁰ лүгээ бараалхан мөргөж явсан явдал буй, боолчууд олвоос даруй хуучин

03.yabunjiha songkoi /

явуулсан ёсоор

04.ejen i hesa hesei be baime /

• эзний хишиг зарлигыг гуйн

05.wesimbufi nomon han i doro be udhai erincinjab de bahabufi, guren i gere /

айлтгаад номун ханы тамгыг даруй Эринчинжавт олгуулаад, Хүрээний олон

06.lama bandi sabe hadalabuki, geli baicaci erincinjab, sanjodba gomjobab juwe /

лам банди нарыг захиргасугай, бас байцааваас, Эринчинжав, шанзодба Гомбожав хоёр

07.niyalma aniyaderi halayame gemu hace de tosifi /

хүн жил бүр ээлжлэн цөм нийслэл*²¹ хотод орж

08.abai genggiyen be harasame ginggilere idu bisire tade, kemuni ubi hufa /

*¹⁶ Жанчувдорж - Их шавийн Мэргэн хамба хутагтын III дүр, 1758 онд Их шавийн Сандув хэмээх айлд төрсөн гэдэг. Сайшаалт ерөөлтийн 11-р (1806) онд Их хүрээний хамба номун ханы тушаал хүлээж, 1820 онд өөд болжээ.

*¹⁷ Гомбожав - Сайшаалт ерөөлтийн 16-р (1811) оноос Төр гэрэлтийн 16-р он (1836)-д Их Хүрээний Эрдэнэ шанзодбын тушаал хүлээн 26 жил ажиллажээ.

*¹⁸ Эринчинжав - Их шавийн долоон хутагтын нэг болох Эрдэнэ ялгуусан хутагтын IV дүр, Төр гэрэлтийн 2-р (1822) онд Хамба номын ханы тушаалд томилогдон 9 жил ажиллажээ.

*¹⁹ Лувсанхайдав - Тухайн үеийн манж, монгол бичгүүдэд Агваанхайдавын нэрийг "Лувсанхайдав", "Хайдав", "Агваанхайдав" гэх зэргээр бичсэн байдаг.

*²⁰ Тэнгэрийн гэгээн - Манжийн хааныг ийнхүү өргөмжилөн нэрлэж байв.

*²¹ Нийслэл - Бээжин хотыг хэлж буй.

- тэнгэрийн гэгээн лүгээ бараалхан мөргөх жасаа бүхий угтаа, цөм эндэхийн бусад
09.jukdaha i lamasa be baicame nomon hural be baicame yabure hancin bi, /
сүмийн лам нарыг байцаан ном хуралыг байцаан явах зүйл буй,
10.erincinjab i sirame doro daisalara niyalma aku oci, duihunde wonduhulere de /
Эринчинжавын дараа тамга хамаарах хүн үгүй болвоос, урьдаас хийлхүйд
11.isinara, be dahame /
хүрч одох тул дагаж
(27 b)
01.enduringge ejen aikan ahasa i baiha songkoi /
богд эзэн хэрэв боолчуудын гуйсан ёсоор
02.hesei isibume erincinjab be nomon han sindara oci, bahaci adabume budlaha corji /
хишиг хүртээж Эринчинжавыг номун хан тавих болвоос олвоос дашлуулаар
мэдүүлсэн цорж
03.lubsanhaidab tehi wuncere se, niyalma honu gideken, nomon de inu sain, /
Лувсанхайдав 40 илүү нас, хүн харин ч тодорхой, номд мөн сайн,
04.udhai guren i ilhi lama ofi, erincinjab yaya alban de tucige /
даруй Хүрээний дэс лам болгон, Эринчинжав аливаа албанд гарсан
05.manggi doro daiselebume gere lamasa be kadalabume wonduhulere de /
хойно тамга хамааруулан олон лам нарыг захируулж хийлхүйд
06.isiburaku obuki, erincinjab se aikan meimeni afaha tosan i baita de /
хүргэхгүй болгосугай, Эринчинжав нар хэрвээ өөр өөрийн тушаалын хэрэгт
07.kiceme fasasaraku bederecere bedhuasra hacin bici, nereginde wakalame, /
хичээж зүтгэхгүйд хүрэх залхуурах зүйл буй бөгөөс, учирьг буруушаан
08.wesimbufi, nakabume icihiyaki, ahasa hulgindeme hunihangge uddu, ocoro ocoraku /
айлтгасугай, байлгаж шийтгэсүгэй, боолчууд мунхаглан санасан, ийнхүү болох болохт
09.babe bairangga /
явдлыг гуйх нь
10.enduringge ejen genggiyen i bulehusefi /
богд эзэн гэгээнээ толилон
11.tacibume hese wesimbuha manggi, gingguleme dahame yabuki, erei jalin suwaliyame
сургах зарлиг айлтгасан хойно, хичээнгүйлэн дагаж явтугай, энэ хэргийг
12.gingguleme /
хичээнгүйлэн
(28 a)
01.wesimbuhe, /
айлтгав,
02.hese be baimbi seme /
зарлигыг гуйв хэмээн
03.wesimbuhede, ineku aniyan ineku biyai orin duin de alime gaiha de bukderi de /
айлтгасанд, мөнхүү жил мөнхүү сарын хорин дөрвөнд эвхмэлд
04.wulgiyen wei pileche /
улаан бийрээр цохов*
05.hesa hese wesimbuha ”
хишиг зарлиг буулгав,”

гэжээ.

Энд бичсэнээр Сайшаалт ерөөлтийн 25-р (1820) онд Хүрээний хамба номун хан Жанчувдорж жанч халсан учир зарлигаар цорж Лувсанпэринлэйдандарыг тушаалд томилсон бөгөөд тэрбээр Төр гэрэлтийн хоёрдугаар (1822) оны таван сарын 24-нд өвчинөөр өөд болжээ.

Хүрээний хамба номун хан жанч жалсан тул түүний тамгыг Шанзодба Гомбожавт түр хамааруулж, ихээхэн лам нар зөвлөлдөн Жибузундамба хутагтын харьяат Эринчинжав,

цорж Лувсанхайдав хоёрын нэрийг цохон ирүүлсэнд Юндэндорж нар байцаан үзээд Эринчинжавыг Хүрээний хамба номун ханы тушаалд тавих тухай мэдүүлэхийн зэрэгцээ түүнийг аливаа албанд явсан үед хэргийг хамаарах “дэс лам” /дэд хамба/-ын тушаалыг буй болгож, цорж Агваанхайдавыг томилохыг гуйн айлтгажээ.

“Дэс лам”-ын тушаал бий болгох болсон учрыг бичигт “... Эринчинжав, шанзодба Гомбожав хоёр хүн жил бүр ээлжлэн цөм нийслэл хотод орж тэнгэрийн гэгээн лүгээ бараалхан мөргөх жасаа бүхий угтаа, цөм эндэхийн бусад сүмийн лам нарыг байцаан ном хуралыг байцаан явах зүйл буй Эринчинжавын дараа тамга хамаарах хүн үгүй болвоос, урьдаас хийлхүйд хүрч одох тул...” тодорхойлсон байна.

Айлтгалыг үндэслэвэл, тухайн үед 40 илүү настай Агваанхайдав дэд хамбын тушаалд суухад доорх гурван зүйл нөлөөлжээ. Үүнд,

1. Хүрээний томоохон лам нар түүнийг хамба номун ханы тушаалд тавихаар Эринчинжавын хамт нэр мэдүүлсэн
2. Бие хүний хувьд олонд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн. Үүнийг айлтгалд “...хүн харин ч тодорхой...” хэмээжээ
3. Буддын гүн ухаан, ном эрдэмд төгс боловсорсон. Энэ чанарыг айлтгалд “Агваанхайдав ... номд мөн сайн” хэмээн энгийн агаад гүн гүнзгий утга

бүхий үгээр илэрхийлсэн байна.

Хүрээний сайд Юндэндорж нарын газраас ийнхүү тодорхойлон айлтгасан бичгийг Манжийн Төр гэрэлт хаан гэгээнээ толилоод, мөнхүү сарын хорин дөрвөнд улаан бийрээр цохож, зарлиг хичээнгүйлэн дагаж явсугай хэмээжээ.

2.2. Төр гэрэлт хааны зарлиг:

Манжийн Төр гэрэлт хаанаас Хүрээний сайдын газраас ирүүлсэн бичгийн хариуд буулгасан зарлигын хуулга нь өгүүлэн буй дансны 29 дүгээр нүүрэнд байна.

Бичгийн он цагаас үзвэл, Манжийн хаан Төр гэрэлтийн хоёрдугаар оны долоон сарын арван таванд Эринчинжавыг номун хан, Лувсанхайдавыг Хүрээний дэс ламаар тус тус томилон зарлиг бичиг буулгасныг долоон сарын хорин долоонд данснаа хуулжээ. Үүнийг дор сийрүүлбэл дараах мэт:

(29 а)

01. nadan biyai orin duin de alime gaiha

• долоон сарын хорин долоонд

02. doro eldengge-i jai aniya nadan biyai towohon de

төр гэрэлтийн хоёрдугаар оны долоон сарын арван таванд*²²

03. hese wesimbuhengge, yundundorji sei baci, lubsanperenleidandar i tucige nomon han i oronde зарлиг буулгасан нь, Юндэндорж нарын газраас, Лувсанпэринлэйдандарын гарсан номун ханы оронд

04. cohero adabume niyalma tomilafi sindara be baime wesimbuhebi, erebe yundundorji sei цохуулж дашлуулах хүн томилон тавихыг гуйн айлтгав, үүнийг Юндэндорж нарын

05. wesimbuhe sonkoi lubsanperenleidandar i tucige nomon han i oronde cohero hubilgan айлтгасан ёсоор Лувсанпэринлэйдандарын гарсан номун ханы оронд цохон хувилгаан

06. erincinjab be sindefi kuren i geren lama bandi sabe hadalabu, adabuha corji lubsanhaidab Эринчинжавыг тавьж Хүрээний лам банди нарыг захирга, дашлуулах цорж Лувсанхайдав

*²² Төр гэрэлтийн хоёрдугаар оны долоон сарын арван таван - Энэ нь аргын тооллын 1822 оны 9 сарын 9-ний өдөр ажээ. - В.В.Цыбульский. Лунно-соличный календарь стран Восточной Азии. С переводом на даты Европейского календаря (с 1 п 2019 г.н.э). М., 1987. стр.346

07. niyalma gedugen, nomon de sain be dahame, udhai kuren i ilhi lama obufi, erincinjab yaya
хүн тодорхой, номд мөн сайныг дагаж, даруй Хүрээний дэс лам болгоод, Эринчинжав
аливаа

08. alban de tucige manggi imbe nomon han i doro be daiselebume geren lamasa be hadalabuki sehe
албанд гарсан хойно түүний номун ханы тамгыг хамааруулан олон лам нарыг
захируулсугай хэмээв

гэжээ.

Зарлигын агуулга нь Хүрээний сайд Юндэндорж нарын газраас Хүрээний хамба
номун хан, дэд ламын тухайд өргөн мэдүүлсэн айлтгалыг тэдний гуйсан ёсоор болгож,
Эринчинжав, Лувсанхайдав нарыг номун хан, дэс ламын тушаалд суулгасугай хэмээжээ.

Дээр өгүүлсэн зүйлээс үзэхэд,

- Сайд Юндэндоржийн айлтгалыг Төр гэрэлт хаан улаан бийрээр цохож, цорж
Агваанхайдав Хүрээний анхны дэс лам /дэд хамба/-ын тушаалд суужээ
- Айлтгалаас харахад, цорж Агваанхайдав өөрийн эрдэм чадал, олонд хүндлэгдсэн
чанараараа Хүрээний дэд хамбын тушаалд суусан байна.
- Тухайн үеийн манж хуулга дансыг үндэслэвэл, Хүрээний дэд хамбыг эхэн үедээ
“дэс лам” хэмээн нэрлэж, бичиж байжээ.

Төгсгөлд нь хэлэхэд, Үндэсний Төв Архивын “Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын
ям”(ҮТА.ФМ-1.)-ны фондод буй манж хэлээрх данс хараанд Агваанхайдав төдийгүй
Хүрээний бусад хамба номун хан, дэд хамба, цорж, да лам нарын намтар, түүхэнд
холбогдох үлэмж баримт хэрэглэгдэхүүн агуулагдаж байгаа бөгөөд тэдгээрийг цаашид
судлан, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Abstract:

TWO DOCUMENTATIONS OF MANCHU SCRIPT RELATED TO BIOGRAPHY OF KHAMBA NOMUN
KHAN AGVAANHIADAV, AN ABBOT OF LAMASERY IN IKH KHUREE

In this record two documentations of manchu script related to biography of Agvaanhiadav wich is kept in
Central National Archive of Mongolia, are researched and it is clarified that Agvaanhiadav decame the first vice
abbot of lamasery in Ikh Khuree.

Ном зүй:

Эх сурвалж:

1. “Хүрээн дэх манж сайдын яамнаас Манжийн хаанд айлтгасан хэрэг, Манжийн
хаанаас буулгасан зарлигуудын хуулга данс” (ҮТА. ФМ-1, Т-1, ХН-812.)

Судалгааны зохиол:

2. Алтангэрэл Ч. Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл. I дэвтэр. УБ., 1967
3. Гомбожав С. Монголчуудын төвд хэлээр зохиосон зохиолын зүйл. // Монголын судлал
(Studia Mongolica). Tom. I. УБ., 1959
4. Дагвадорж Ч. Монголын шашин суртахууны тайлбар толь. УБ., 1995
5. Ү.Дэлгэрмаа “Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд”-ын яамны
баримтын тойм. - Монгол улсын архивын албаны түүхэн хөгжил, орчин үе
(ЭШБХурлын эмхтгэл). УБ., 2001. т.64-85

IV. ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

6. Жигмэддорж Э. Халх-Манжийн улс төрийн харилцаа. УБ., 2008
7. Монгол улсын түүх. Дөтгөөр боть. УБ., 2003
8. Монголын уран зохиолын дээж. I боть. УБ., 1995
9. Монголын хүрээ хийдийн түүх. Эмхтгэсэн Ч.Банзрагч, Б.Сайнхүү. Хянан нягталсан Ш.Сонинбаяр, Г.Дашням. УБ., 2004
10. Монголын философийн түүх (XVII-XIX зуун). УБ., 2001
11. Сонинбаяр Ш. Өндөр гэгээн ба Баруун хүрээний түүх. УБ., 1995
12. Ц.Сономдагва. Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт (1691-1911). УБ., 1961
13. Сэрээтэр Ө. Монголын Их хүрээ, гандан хийдийн түүхэн бүтэцийн товч. 1651-1938. УБ., 1999
14. Хүрэлбаатар Л. Огторгуйн цагаан гарди. УБ., 1996
15. Цыбульский В.В. Лунно-соличный календарь стран Восточной Азии. С переводом на даты Европейского календаря (с 1 п 2019 г.н.э). М., 1987
16. Чулуунбаатар Л. Төвдөөр гийсэн монгол мэргэд. УБ., 2004